



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/377

Мандалговь

Өсвөрийн циркчдийн IV их наадамд  
оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.10, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.8 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Гавьяат жүжигчин, Зууны манлай, Алдарт уртын дуучин Ж.Дорждагвын нэрэмжит “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театрын циркийн дугуйлангийн багш, сурагчид Орхон аймагт зохион байгуулагдах Өсвөрийн циркчдийн IV их наадамд оролцоход түлш шатахууны зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Түлш шатахууны зардалд 500000 (Таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Өсвөрийн циркчдийн IV их наадамд амжилттай оролцохыг “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театр (А.Ууганбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48819107С